



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 230.

Улаанбаатар хот

“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Ерөнхий захирал Х.Бадамсүрэнтэй байгуулсан 2020 оны контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнтэй контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу шинэчлэн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.



3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



132007702

ТӨБЗГ тогтоол-/2021